



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2018 ХОЁРДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2018 оны 2 дугаар улиралд 293 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 377 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 93 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -177 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 186 сая ам.доллараар буурсан, санхүүгийн дансны ашиг 11 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 2,989 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27% -иар өсч 3,608 сая ам.долларт хүрсэн ба худалдааны тэнцэл 355 сая ам.долларт хүрч, сүүлийн 16 улирал дараалан ашигтай гараад байна.

Үүнд зэсийн баяжмалын экспорт 167 сая ам.доллараар (43%), чулуун нүүрсний экспорт 156 сая ам.доллараар (21%) тус тус өссөн хэдий ч СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 258 сая ам.доллараар (57%), хэрэглээний бүтээгдэхүүний импорт 76 сая ам.доллараар (22%) өссөнөөр барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Үйлчилгээний худалдаа

2018 оны 2 дугаар улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 25%-иар буюу 65 сая ам.доллараар өсч 321 сая ам.долларт хүрсэн.

Энэхүү алдагдлын өсөлтөд тээврийн үйлчилгээний дансны алдагдал 44 сая ам.доллараар, бусад үйлчилгээний алдагдал 22 сая ам.доллараар өссөн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 414 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буюу 16 сая ам.доллараар буурсан.


Тайлант улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 81 сая ам.доллар, ногдол ашигт 59 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдын зээлийн хүүгийн төлбөрт 70 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 160 сая ам.доллар болон арилжааны банкууд харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 9 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2018 оны 2 дугаар улиралд Монгол улс нийт 60 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 20 сая ам.доллараар их орлогыг хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оны мөн үеэс 30%-иар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 23%-иар тус тус өсч, цэвэр дүнгээр 41 сая ам.долларын орлого хүлээн авчээ.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 13 сая ам.доллараар өссөн байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2018, II улирал(улсаар, мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	34,148	55%	▲ 96%	2,442	9%	▼ -90%
Америк	9,933	16%	▲ 31%	3,819	14%	▼ -41%
Хятад	554	1%	▼ -71%	1,403	5%	▼ -61%
Гонг Конг	866	1%	▲ 24%	136	1%	▼ -89%
Англи	1,022	2%	▼ -74%	1,056	4%	▼ -72%
ОХУ	683	1%	▼ -7%	2,269	8%	▲ 118%
Сингапур	790	1%	▲ 54%	1,633	6%	▲ 79%
Швейцарь	1,215	2%	▲ 5x	163	1%	▲ 100%
Герман	1,504	2%	▲ 42%	1,031	4%	▼ -17%
Япон	1,194	2%	▲ 23%	828	3%	▼ -47%
Бусад	10,605	17%	▼ -24%	11,928	45%	▲ 66%
НИЙТ	62,516	100%		26,707	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2018 оны 2 дугаар улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 534 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 106 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 428 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 2 сая ам.доллараар буурсан байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 213 сая ам.доллараар өсч 336 сая ам.доллар,
- Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 11 сая ам.доллараар өсч 34 сая ам.долларт хүрсэн бол,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 87 сая ам.доллараар буурч 25 сая ам.доллар,
- Гонг-Конг улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 43 сая ам.доллараар буурч 12 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2018 оны 2 дугаар улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 51 сая ам.доллараар,
- Уул уурхайн салбар 37 сая ам.доллараар,
- Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар 27 сая ам.доллараар тус тус өсч,
- Харин бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 53 сая ам.доллараар,
- Тээвэр агуулахын үйл ажиллагаа 37 сая сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2018 оны 2 дугаар улиралд 274 сая ам.долларын ашигтай гарсан.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Димсам бондын үндсэн болон хүүгийн төлбөрт 147 сая ам.доллар,
- Засгийн газар Мазаалай, Гэрэгэ болон Чингис бондын хүүгийн эргэн төлөлтөд нийт 75 сая ам.доллар,
- Арилжааны банкууд болон аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн гаргасан бондын хүүгийн төлбөрт нийт 42 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст тус тус төлжээ.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд болох арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд манай улсад орсон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэр 86 сая ам.долларын орох урсгалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 318 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд Засгийн газрын болон арилжааны банкуудын зээлийн ашиглалт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	II улирал		2018.II/17.II
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт
1	Австрали	2.0	0%	-1.7
2	Америк	0.0	0%	-40.2
3	Англи	7.8	1%	2.9
4	БНХАУ	25.2	5%	-87.2
5	Герман	-4.4	-1%	-32.9
6	Голланд	0.2	0%	-6.8
7	Гонг-Конг	12.2	2%	-43.2
8	Канад	335.9	63%	213.2
9	Люксембург	47.2	9%	-13.1
10	ОХУ	3.5	1%	-8.7
11	Сингапур	1.2	0%	-51.2
12	Солонгос (өмнөд)	2.7	0%	2.1
13	Турк	0.0	0%	-0.1
14	Франц	-1.5	0%	-1.5
15	Япон	34.2	6%	11.1
16	Бусад	68.2	13%	55.4
	Нийт	534.3	100%	-1.9


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	II улирал		2018.II/17.II
		2017	2018	Өөрчлөлт
1	Барилга	14.1	5.2	-8.9
2	Боловсрол	0.1	0.2	0.1
3	Боловсруулах үйлдвэрлэл	5.4	2.3	-3.1
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	58.0	5.4	-52.6
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	30.2	9.9	-20.2
6	Мэдээлэл, холбоо	-7.9	0.8	8.7
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.8	3.1	0.3
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	7.9	58.8	50.8
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	38.5	1.2	-37.4
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	11.7	10.4	-1.2
11	Уул уурхай, олборлолт	357.8	394.9	37.1
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11.4	6.5	-4.9
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.4	31.6	27.1
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.0	0.2	-0.8
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	2.0	1.8
16	Бусад	0.7	1.9	1.2
	Нийт	536.2	534.3	-1.9

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 оны 2 дугаар улирлын эцэст цэвэр дүнгээр 32,679 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 5,621 сая ам.доллар байна. Үүний 53%-ийг гадаад валютын албан нөөц, 33%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 38,300 сая ам.долларт хүрчээ. Үүний 50%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 39%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 6%-иар буюу 1,685 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 45%-иар буюу 1,732 сая ам.доллараар, гадаад пассив 10%-иар буюу 3,482 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 2,074 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 4 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 1,258 сая ам.доллараар тус тус буурснаар болон албан нөөц 1,258 сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -369 сая, ханшийн өөрчлөлтөөр -115 сая, бусад өөрчлөлтөөр 161 сая, үнийн өөрчлөлтөөр 135 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 55%-ийг буюу 10,525 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 45% буюу 8,443 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 5354 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 28%,
- БНХАУ-аас 4,680 сая ам.доллар буюу 25%,
- Сингапур улсаас 1,627 сая ам.доллар буюу 9%,
- Люксембург улсаас 1462 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг манай улсад тус тус оруулсан байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2018 оны 2 дугаар улирлын эцэст 279 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 4,360 сая ам.долларт хүрч 4%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Актив: Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Гонг конг 47%, Сингапур 13%, АНУ 13%, Англи 7%, Лексембург 6%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 17%, Англи 9%, Сингапур 6%, Хонг Конг 4%, Лексембург 5%, бусад улс 5%, үлдсэн 54% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа учраас хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2017	6/30/2018	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-30,994	-32,679	1,685	5%
I. Гадаад актив	3,889	5,621	1,732	45%
1. Шууд хөрөнгө оруулалт	462	502	41	9%
2. Багцын хөрөнгө оруулалт	266	279	13	5%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	01	06	05	709%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,841	1,844	03	0%
5. Нөөц актив	1,319	2,989	1,670	127%
II. Гадаад пассив	34,883	38,300	3,417	10%
1. Шууд хөрөнгө оруулалт	16,854	18,969	2,115	13%
2. Багцын хөрөнгө оруулалт	4,343	4,360	17	0%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	01	25	24	2466%
4. Бусад хөрөнгө оруулалт	13,686	14,947	1,261	9%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2018 оны 2 дугаар улирал



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2018 оны 2 дугаар улирал



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2018 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 27,745 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,176 сая ам.доллараар өссөн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 898 сая ам.доллараар өсч 6,915 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 188 сая ам.доллараар өсч 2,065 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,025 сая ам.доллараар өсч 18,702 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2018 оны 2 дугаар улиралд 2,300 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 123 сая ам.доллараар өсчээ.

Гадаад өрийн 41%-ийг урт хугацаат зээл, 26%-ийг бонд өрийн бичиг, 21%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 12%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 938 сая ам.доллар, 472 сая ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2018 оны 2 дугаар улирлын эцэст 18,702 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,025 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 45% буюу 8,443 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 341 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	6/30/2017	6/30/2018	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	25,569	27,681	2,112	8%	100%
I. Засгийн газар	6,016	6,915	898	15%	25%
Бонд, өрийн бичиг	2,986	2,981	(4)	0%	
Зээл	3,031	3,933	903	30%	
II. Төв банк	1,877	2,065	188	10%	7%
III. Банк	2,177	2,300	123	6%	8%
Богино хугацаат	721	769	48	7%	3%
Урт хугацаат	1,456	1,531	74	5%	6%
IV. Бусад сектор	7,891	7,959	68	1%	29%
Богино хугацаат	541	642	102	19%	2%
Урт хугацаат	7,350	7,316	(34)	0%	26%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,609	8,443	835	11%	31%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ,

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	II улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2016	2017	2018	Дүн	2017/16	Дүн	2018/17
I. УРСГАЛ ДАНС	-348	-120	-319	227	65%	-199	-165%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-189	270	34	459	243%	-236	-87%
Кредит	1,388	1,930	2,264	541	39%	334	17%
Дебет	1,577	1,660	2,229	82	5%	570	34%
1. Бараа	248	527	355	278	112%	-171	-33%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,182	1,683	1,981	501	42%	299	18%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	934	1,156	1,626	222	24%	470	41%
2. Үйлчилгээ	-437	-257	-321	181	41%	-65	-25%
Кредит	206	247	282	41	20%	35	14%
Дебет	644	504	603	-140	-22%	99	20%
2.1 Тээвэр	-50	-89	-133	-39	-79%	-44	-50%
Кредит	72	84	101	12	17%	17	20%
Дебит	121	173	234	52	42%	61	35%
2.2 Аялал	-48	-16	-15	32	66%	1	9%
Кредит	67	98	111	31	47%	13	14%
Дебит	115	114	126	0	0%	12	10%
2.3 Бусад үйлчилгээ	-340	-152	-173	188	55%	-22	-14%
Кредит	68	65	70	-3	-4%	5	8%
Дебит	408	217	243	-191	-47%	27	12%
3 Анхдагч орлого	-222	-430	-414	-209	-94%	16	4%
Кредит	18	20	27	2	9%	7	35%
Дебет	240	450	441	210	88%	-9	-2%
3.1 Ажилчдын цалин	-3	-9	-12	-6	-187%	-3	-30%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-218	-422	-404	-204	-93%	18	4%
3.3 Бусад	0	1	2	1		1	
4 Хоёрдогч орлого	63	40	60	-23	-37%	20	52%
Кредит	85	62	90	-22	-26%	28	44%
Дебет	22	23	30	1	5%	7	32%
Үүнээс: Хувийн гуйвуулга	19	3	7	-16	-84%	4	138%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	23	14	27	-9	-39%	13	93%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	23	14	27	-9	-39%	13	93%
Кредит	23	15	27	-8	-36%	12	82%
Дебет	1	1	1	0	60%	0	-34%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-325	-107	-293	219	67%	-186	-175%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-306	-365	-377	-59	-19%	-11	-3%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-306	-365	-377	-59	-19%	-11	-3%
1. Шууд хөрөнгө оруулалт	4,534	-394	-424	-4,928	-109%	-30	-8%
1.1 Актив	1	5	4	3	225%	-1	-22%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1	5	4	3	225%	-1	-22%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	0	0	0	#DIV/0!	0	
1.2 Пассив	-4,533	399	428	4,931	109%	29	7%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-405	181	263	585	145%	83	46%
1.2.2 Өрийн хэрэгсэл	-4,128	218	164	4,346	105%	-53	-25%
2. Багцын хөрөнгө оруулалт	-504	-67	274	437	87%	341	507%
2.1 Актив	0	-4	16	-4	-1092%	20	492%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	0	-4	13	-5	-1189%	17	400%
2.1.2 Өрийн бичиг	0	0	2	0	#DIV/0!	2	
2.2 Пассив	504	63	-258	-441	-87%	-322	-508%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	4	-1	-1	-5	-119%	0	-24%
2.2.2 Өрийн бичиг	500	64	-257	-436	-87%	-321	-502%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	0	-1	-41	-1	17x	-40	-6801%
3.1 Актив	-4	0	-21	5	105%	-22	-10232%
3.2 Пассив	-5	1	19	5	117%	19	2317%
4. Бусад хөрөнгө оруулалт	-4,337	97	-185	4,433	102%	-282	-292%
4.1 Актив	-56	-135	-99	-79	-141%	36	27%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	-66	-165	-112	-99	-151%	53	32%
4.1.3 Зээл	1	0	-28	-1	-130%	-28	-15698%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	10	31	42	21	223%	11	79x
4.1.5.1 Богино хугацаат	10	31	42	21	223%	11	79x
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	4,281	-232	86	-4,512	-105%	318	137%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	-267	52	-49	319	120%	-101	-193%
4.2.3 Зээл	4,526	-216	70	-4,742	-105%	287	133%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	60	-218	1	-277	-465%	219	101%
4.2.3.3.1 Богино хугацаат	4	-75	33	-79	-1935%	108	144%
4.2.3.3.2 Урт хугацаат	56	-142	-32	-198	-357%	111	78%
4.2.3.2 Засгийн газар	119	83	133	-35	-30%	50	60%
4.2.3.4 Бусад салбар	4,348	-82	-64	-4,430	-102%	18	22%
4.2.3.4.1 Богино хугацаат	44	0	-40	-45	-101%	-39	-8566%
4.2.3.4.2 Урт хугацаат	4,304	-81	-24	-4,385	-102%	58	71%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	21	-68	65	-89	-417%	132	195%
4.2.5.1 Богино хугацаат	73	-68	65	-141	-192%	132	195%
4.2.5.2 Урт хугацаат	-52	0	0	52		0	
4.2.6 Бусад авлага	0	0	0	0	#DIV/0!	0	
4.2.7 Зээлжих тулсгай эрх	0	0	0	0		0	
IV. Алдаа болон орхигдуулга	11	-169	-177	-179	-17	-8	0
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	-8	90	-93	98	1194%	-183	-204%
1. ГВУН	-8	128	-93	136	1662%	-221	-173%
2. ОУВС-гийн зээл	0	38	0	38		-38	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	3/31/2017	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/31/2018	6/30/2018
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(28,632)	(29,353)	(30,265)	(30,994)	(31,333)	(32,033)	(32,592)	(32,679)
Актив	3,907	4,309	3,819	3,889	4,466	5,553	5,684	5,621
Шууд хөрөнгө оруулалт	440	455	459	462	478	495	501	502
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	366	380	383	386	409	427	437	440
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	366	380	383	386	409	427	437	440
Өрийн хэргэсэл	73	75	76	76	69	68	64	62
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	72	75	75	75	68	68	63	61
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	1	1	1	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	223	280	279	266	257	268	274	279
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	213	259	269	255	244	254	260	263
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	3	3	45	42	17	18	28	29
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	210	256	223	213	226	236	232	234
Бусад санхүүгийн байгууллага	163	165	165	165	165	168	176	189
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	47	91	5	5	4	5	3	45
Өрийн бичиг	10	21	11	11	13	14	14	17
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	6	17	6	6	6	6	6	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	4	4	5	5	7	8	8	10
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	114	100	1	1	1	(0)	6	6
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	114	100	1	1	1	(0)	6	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	1,807	2,178	1,971	1,841	2,104	1,782	1,920	1,844
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,443	1,746	1,516	1,355	1,650	1,328	1,547	1,473
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	441	762	654	525	750	461	605	643
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	441	762	654	525	750	461	605	643
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	1,002	984	862	830	900	867	943	830
Богино хугацаат	0	0	862	830	900	867	943	830
Урт хугацаат	1,002	984	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Зээл	50	62	65	65	60	61	60	60
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	49	61	61	62	60	60	60	60
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	1	1	4	3	(0)	2	(0)	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	1	1	4	3	(0)	2	(0)	0
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0	0
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад сектор	0	0	0	0	0	0	0	0
Ердийн даатгалын техникийн нөөц сан (F61O)	0	0	0	0	0	0	0	0
Амьдралын даатгал ба жил бүрийн даатгал (F62O)	0	0	0	0	0	0	0	0
Тэтгэмжийн эрх	0	0	0	0	0	0	0	0
Тэтгэвэрийн сангийн нөхөн төлбөр (F64O)	0	0	0	0	0	0	0	0
Тэтгэмжийн эрх (F65O)	0	0	0	0	0	0	0	0
Стандарт баталгааны эрсдлийн сан (F66O)	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьчлалга	314	370	390	421	394	392	313	310
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	314	370	390	421	394	392	313	310
Богино хугацаат	262	319	389	420	394	392	313	310
Урт хугацаат	52	51	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	314	370	390	421	394	392	313	310
Богино хугацаат	262	319	389	420	394	392	313	310
Урт хугацаат	52	51	0	0	0	0	0	0
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0	0
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	1,323	1,296	1,109	1,319	1,627	3,008	2,983	2,989

Үргэлжлэл.

Гадаад пассив	32,539	33,662	34,083	34,883	35,800	37,586	38,276	38,300
Шууд хөрөнгө оруулалт	20,696	16,277	16,540	16,854	17,378	18,020	18,520	18,969
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	9,575	8,851	8,999	9,245	9,514	10,023	10,286	10,525
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	9,575	8,851	8,999	9,245	9,514	10,023	10,286	10,525
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	11,121	7,426	7,541	7,609	7,864	7,996	8,234	8,443
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	11,121	7,426	7,541	7,609	7,864	7,996	8,234	8,443
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	3,067	3,631	3,863	4,343	4,483	4,937	4,759	4,360
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	80	71	67	67	70	71	71	69
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	11	11	11
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	69	60	56	56	59	60	60	58
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	2,987	3,560	3,796	4,275	4,413	4,866	4,687	4,291
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	652	611	575	562	602	589	608	593
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	652	611	575	562	602	589	608	593
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,473	2,064	2,916	2,986	3,085	3,549	3,340	2,981
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	1,473	2,064	2,916	2,986	3,085	3,549	3,340	2,981
Бусад салбарууд	862	886	304	727	727	728	738	717
Богино хугацаат	2	2	2	2	2	2	2	2
Урт хугацаат	860	884	302	725	724	726	736	715
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	166	116	0	1	(0)	(0)	6	25
Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	166	116	0	1	(0)	(0)	6	25
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	8,610	13,638	13,680	13,686	13,939	14,630	14,992	14,947
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,954	1,965	2,003	2,092	2,225	2,245	2,365	2,210
Төв банк	1,772	1,725	1,741	1,770	1,805	1,837	1,913	1,811
Богино хугацаат	1,772	1,725	1,741	1,770	1,805	1,837	1,913	1,811
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	182	240	253	308	318	314	330	297
Богино хугацаат	0	0	253	308	318	314	330	297
Урт хугацаат	182	240	0	0	0	0	0	0
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	9	14	103	95	122	102
Зээл	6,398	11,457	11,471	11,395	11,428	12,105	12,354	12,395
Төв банк	68	65	66	106	109	188	224	253
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	68	65	66	106	109	188	224	253
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,294	1,567	1,522	1,308	1,311	1,291	1,408	1,410
Богино хугацаат	407	469	488	414	403	345	439	472
Урт хугацаат	887	1,098	1,034	894	908	946	970	938
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	2,287	2,805	2,928	3,031	3,156	3,772	3,902	3,933
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	2,287	2,805	2,928	3,031	3,156	3,772	3,902	3,933
Бусад салбарууд	2,749	7,020	6,955	6,950	6,852	6,853	6,820	6,799
Богино хугацаат	260	218	274	328	310	292	266	271
Урт хугацаат	2,489	6,802	6,681	6,622	6,542	6,560	6,554	6,528
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	2,749	7,020	6,955	6,950	6,852	6,853	6,820	6,799
Богино хугацаат	260	218	274	328	310	292	266	271
Урт хугацаат	2,489	6,802	6,681	6,622	6,542	6,560	6,554	6,528
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	138	216	206	199	286	280	274	341
Бусад дансны авлага/өглөг	120	0	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/30/2015	12/30/2016	3/30/2017	6/30/2017	9/30/2017	12/30/2017	3/30/2018	6/30/2018
Засгийн газар	3,760	4,869	5,844	6,016	6,241	7,321	7,242	6,915
Төвбанк	1,960	1,791	1,807	1,877	1,914	2,025	2,137	2,065
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,129	2,417	2,351	2,177	2,231	2,194	2,346	2,300
Бусад салбарууд	3,749	8,121	7,473	7,891	7,967	7,956	7,954	7,959
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	11,121	7,426	7,541	7,609	7,864	7,996	8,234	8,443
Нийт гадаад өр	22,718	24,625	25,017	25,569	26,216	27,493	27,913	27,681